


МӨНГӨНИЙ ТОЙМ

/2014 оны 12 дугаар сар/



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014									
	12-р сар	3-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар	
Инфляци										
Улаанбаатар хотын инфляци										
сарын	1.7	0.5	0.5	0.6	0.7	1.0	0.8	0.6	0.6	
оны эхнээс	11.2	3.3	6.0	6.6	7.4	8.5	9.4	10.1	10.7	
жилийн	11.2	11.9	15.1	15.4	13.6	13.6	12.7	11.9	10.7	
Суурь инфляци										
сарын	1.3	0.2	0.6	2.2	2.4	1.3	1.5	0.8	0.4	
оны эхнээс	12.1	1.2	3.3	5.6	8.1	9.6	11.3	12.2	12.6	
жилийн	12.1	12.6	15.8	17.9	15.6	15.5	14.1	13.6	12.6	
Улсын инфляци										
сарын	0.7	0.8	0.5	0.4	0.4	0.7	0.8	0.7	0.8	
оны эхнээс	11.9	3.5	6.7	7.2	7.7	8.5	9.3	10.1	11.0	
жилийн	11.9	12.4	14.6	14.9	13.7	13.0	12.1	11.5	11.0	
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр	9 454.9	9 949.4	10 107.0	10 078.2	10 136.0	10 074.3	9 973.3	9 928.1	10 635.8	
сарын өөрчлөлт, %	3.9	1.0	-1.3	-0.3	0.6	-0.6	-1.0	-0.5	7.1	
жилийн өөрчлөлт, %	24.2	36.3	26.3	24.6	20.5	18.8	14.4	9.1	12.5	
Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр	7 361.7	8 212.1	8 244.9	8 379.8	8 261.3	8 238.0	8 221.5	8 238.4	8 819.1	
сарын өөрчлөлт, %	1.2	1.5	-2.0	1.6	-1.4	-0.3	-0.2	0.2	7.0	
жилийн өөрчлөлт, %	27.4	43.8	37.9	36.0	27.9	27.4	21.3	13.3	19.8	
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр	841.1	801.2	860.0	859.6	880.1	827.3	809.6	769.0	809.7	
сарын өөрчлөлт, %	4.6	5.9	-0.3	-0.1	2.4	-6.0	-2.1	-5.0	5.3	
жилийн өөрчлөлт, %	1.5	16.5	2.9	3.3	1.4	-5.4	-1.8	-4.3	-3.7	
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр	3 335.5	3 127.5	2 882.2	2 905.1	2 814.8	2 826.5	2 707.7	2 679.5	3 426.5	
сарын өөрчлөлт, %	18.1	-0.1	-4.2	0.8	-3.1	0.4	-4.2	-1.0	27.9	
жилийн өөрчлөлт, %	54.0	26.7	-17.9	-6.4	8.2	-4.0	2.4	-5.1	2.7	
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	10 764.2	11 380.9	12 302.1	12 225.4	12 338.4	12 611.5	12 833.5	12 648.4	12 502.5	
сарын өөрчлөлт, %	-0.5	2.0	2.0	-0.6	0.9	2.2	1.8	-1.4	-1.2	
жилийн өөрчлөлт, %	54.0	54.0	42.9	34.1	26.1	24.2	22.4	16.9	16.1	
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар	5.26	5.22	4.61	4.91	5.02	4.68	4.72	4.90	5.00	
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар (Хадгаламж, Анод, Зоос-ыг хассанаар)	2.48	2.57	2.72	3.00	3.16	2.84	2.91	3.06	3.10	
Хүү										
Хадгаламжийн ЖДХ	12.1	12.2	12.2	12.2	12.2	12.3	12.6	12.7	12.5	
Зээлийн ЖДХ*	17.4	19.7	18.8	19.2	19.6	18.3	18.9	18.6	19.5	
Монголбанкны ҮГХ зээлийг оруулсан ЖДХ*	14.9	17.8	17.3	17.5	17.6	16.3	16.9	17.1	16.9	
Ипотекийн зээлийн ЖДХ	9.90	9.90	10.5	10.7	10.5	10.6	10.4	10.3	9.9	
ТБҮЦ-ны ЖДХ	10.5	10.6	10.6	10.6	11.8	12.1	12.1	12.1	12.1	
Бодлогын хүү	10.5	10.5	10.5	12.0	12.0	12.0	12.0	12.0	12.0	
БХЗ-ын ЖДХ	8.9	9.4	10.4	10.8	12.4	12.4	12.7	12.4	12.2	

* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2014 оны 12 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны мөн үеэс 11.0 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.6 хувь, өмнөх оны мөн үеэс 10.7 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 0.4 хувь, жилийн 12.6 хувь байв.

Тухайн сард хүнсний ногооны үнэ 6.3 хувь, жимсний үнэ 2.9 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 2.2 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүний үнэ 0.9 хувь хувиар өсч хүнсний барааны бүлгийн үнэ 1.1 хувиар өссөн байна. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.2 хувиар өссөн нь согтууруулах ундааны үнэ 5.7 хувь, хувцас, бөс бараа 0.9 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ 0.7 хувиар өссөнтэй холбоотой байна. Харин нүүрсний үнэ 10.9 хувиар буурчээ.

Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 89 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 12 бараа үйлчилгээнийх буурсан байна.




Жилийн инфляцийн 20.0 хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 80.0 хувийг хүнснээс бусад барааны бүлгийн үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 22.1 хувь (жилийн өсөлтийн 28.3 хувь), боловсрол 17.7 хувь (жилийн өсөлтийн 11.7 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 11.4 хувь (жилийн өсөлтийн 3.2 хувь), согтууруулах ундаа, тамхи 10.4 хувь (жилийн өсөлтийн 4.6 хувь), тээвэр 10.3 хувь (жилийн өсөлтийн 10.8 хувь), хувцас, бөс бараа, гутал 9.2 хувь (жилийн өсөлтийн 11.5 хувь), гэр ахуйн тавилга, бараа 8.5 хувь (жилийн өсөлтийн 2.7 хувь), бусад бараа үйлчилгээний бүлэг 9.1 хувиар (жилийн өсөлтийн 3.2 хувь) тус тус өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлт


Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 7.1 хувь, өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар өсч 10635.8 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 50.9 хувийг төгрөгийн хадгаламж, 18.5 хувийг валютын хадгаламж, 13.5 хувийг валютын харилцах, 12.4 хувийг төгрөгийн харилцах, 4.7 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Тайлант сард төгрөгийн харилцахын жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 12.6 нэгж хувиар буурсан бол, гадаад валютын харилцахынх 35.4 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 9.8 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 2.7 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийнх 0.4 нэгж хувиар өссөн байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж 433.1 тэрбум төгрөг, гадаад валютын харилцах 53.6 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 94.0 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 75.6 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 51.3 тэрбум төгрөгөөр өсчээ.



Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 42.3 хувийг төгрөгийн хадгаламж, 41.8 хувийг гадаад валютын хадгаламж, 39.4 хувийг гадаад валютын харилцах, -16.4 хувийг төгрөгийн харилцах, -7.0 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 7.7 хувь буюу 527.2 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 15.5 хувь буюу 992.6 тэрбум төгрөгөөр өсч 7380.0 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 13.9 хувь буюу 192.2 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 25.9 хувь буюу 322.9 тэрбум төгрөгөөр өсч 1571.9 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 6.7 хувь буюу 241.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 4.8 хувь буюу 176.0 тэрбум төгрөгөөр өсч 3838.4 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 5.0 хувь буюу 94.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 33.4 хувь буюу 493.6 тэрбум төгрөгөөр өсч 1969.8 тэрбум төгрөг болжээ.



Нийт хадгаламжийн 73.3 хувь нь төгрөгийн, 26.7 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар буурсан байна.

Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 16.3 хувь, өмнөх оны мөн үеэс 1.8 дахин буурснаар -1701.8 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив

өмнөх сараас 13.2 хувь, өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өсч 8934.0 тэрбум төгрөг болов.



Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 27.9 хувь, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өсч 3426.5 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард Төв банк дахь харилцах, хадгаламж 36.9 хувь буюу 706.4 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 17.9 хувь буюу 75.6 тэрбум төгрөгөөр өссөн бол, банкуудын касс 10.2 хувь буюу 35.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.




Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар өсч 76.5 хувь, банкуудын кассын эзлэх хувь 1.3 нэгж хувиар өсч 9.0 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 2.9 нэгж хувиар буурч 14.6 хувь болсон байна.

Зээл


Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд оны эхнээс саарсаар байна. Тухайлбал, тайлант сард өмнөх сараас 0.7 нэгж хувиар буурчээ.

Хадгаламжийн байгууллагуудаас¹ олгосон зээл өмнөх сарынхаас 1.2 хувь буюу 145.8 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувь буюу 1738.4 тэрбум төгрөгөөр өсч 12.5 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 3.0 хувь буюу 206.9 тэрбум төгрөгөөр буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 10.6 хувь буюу 638.3 тэрбум төгрөгөөр өсч 6656.2 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 1.1 хувь буюу 64.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 22.5 хувь буюу 1048.8 тэрбум төгрөгөөр өсч 5707.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

¹Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 53.2 хувь нь хувийн хэвшил, 45.6 хувь нь иргэд, 1.0 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.



Нийт зээлийн үлдэгдлийн 92.8 хувийг хэвийн зээл, 2.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.0 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.3 нэгж хувиар буурсан байна. Татан буугдсан банкуудын


татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

мэдээллийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 3.1 хувьтай байна.

Картын зээл

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.1 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл тайлант сард 262.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар буюу 10.6 тэрбум төгрөгөөр өсчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 2.9 хувиар буюу 7.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Картын зээлийн 95.5 хувь нь хэвийн, 1.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 3.1 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 95.3 хувь нь төгрөгөөр, 4.7 хувь нь валютаар олгогдсон байна

² Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2014 оны 12 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 1.6 нэгж хувиар өсч жилийн 12.12 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өсч жилийн 19.5² хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсч жилийн 12.9 хувь болжээ.




Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 2.8 хувь, валютынх жилийн 1.5 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 12.5 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 5.8 хувь болов.

төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 16.9 хувь байна.

Мөнгөний зах

2014 оны 12 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 2559.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.2 хувь байна.



2014 оны 12 сарын 10-ны өдрөөс 2015 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 885.6 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 435.4 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 910.7 тэрбум төгрөг, валютын нөөцөд 956.5 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2014 оны 12 дугаар сарын эцэст 1888.44 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 229.1 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.

доллартай харьцах дундаж ханш 1883.0 төгрөг байв.

